

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2019.06.25-2019.07.25/

Шивээговь сум үүсч хөгжсөний 30 жилийн ойн баяр наадмыг 2019 оны 07-р сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулж 6-н насны морь уралдаж сур, шагайн харваачид онч мэргэнээ сорьж сурын харвааны эрэгтэй төрөлд “Бурхан халдун” багийн харваач спортын мастер М.Мэндсайхан, эмэгтэй төрөлд Зуун мэргэн холбооны харваач Монгол Улсын Дархан мэргэн Х.Оюунчимэг нар түрүүлсэн.

Хүчит бөхийн барилдаанд 96 бөх барилдсанаас аймгийн арслан Э.Мөнхбаатар түрүүлж, аймгийн арслан Д.Гончигтавхай үзүүрлэн, аймгийн арслан Б.Үүрцайх, Д.Мөнхдорж нар шөвгөрсөн байна. Мөн шигшээ 32 бөхийн барилдаанд Э.Энхтөр түрүүлж “Сумын заан” цол, Э.Болд-Эрдэнэ үзүүрлэж “Сумын харцага” цол, М.Бүрэнтөгөлдөр, П.Батсайхан нар шөвгөрч “Сумын начин” цол тус тус хүртсэн.



Сумын Засаг даргын Зөвлөлийн хурлыг 2019 оны 06-р сарын 21-ний өдөр зохион байгуулж доорх мэдээ, тайлангуудыг хэлэлцэн ИТХТ-ийн хурлаар хэлэлцэн батлуулахаар хүргүүлээ.

Үүнд:

- Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл
 - Мал амьтныг халдварт паразиттх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө
 - Орон нутгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт
 - Сум хөгжүүлэх сан
 - Сумын нутаг дэвсгэрт нохой, муур тэжээх, арчлах, золбин нохой устгахад мөрдөх журам
 - Хог цэвэрлэгээ, тээвэрлэлт, тохижилт, хог хаягдал гаргасны төлбөрийн талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам
 - Иргэдийг малжуулах журам
 - Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих дэд хөтөлбөр
 - Бэлчээр ашиглалтын журам
 - Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр
 - Ажилгүйдэлийг бууруулах арга зам дэд хөтөлбөр
 - Газар зохион байгуулалтын 2019 оны тухайн жилийн төлөвлөгөө
 - Сумын ИТХ-ын тогтоолын хяналтанд авсан заалт
 - Бэлчээр, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

- Сумын хамтарсан баг
- Зорилтот өрхийн хөгжил, нийгмийн хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдах сумын 16 өрхөд хийж буй ажил
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл
- Сумын 2020 он хүртлэх дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө
- Сумын Засаг даргын 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
- Сумын эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Сумын 30 жилийн ой болохтой холбогдуулан сумын байгууллагууд гадна өнгө үзэмжээ сайжруулах тохижилтын ажлуудыг 9 ААНБ хийж гүйцэтгэсэн.



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Сумын ИТХ, ЗДТГ болон аймгийн хэлтэс агентлагуудтай хамтран зохион байгуулсан “Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг”-ийг 2019 оны 06-р сарын 25-ны өдөр сумын төв талбайд зохион байгуулж нийт 7 байгууллагын 25 албан хаагч оролцож, давхардсан тоогоор 294 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлж, 368 брошур, гарын авлага тарааж ажилласан байна. Энэ үеэр аймгийн онцгой байдлын газар, сумын соёлын төв урлагын тоглолтуудыг иргэддээ толилууллаа.



2019 оны 2-р улирлын байдлаар Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 89 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 139 нийт 228 өргөдөл хүлээн авсанаас 225 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна.

Сумын Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/107 дугаар захирамжаар “Улсын баяр наадмын амралтын өдрүүд”-ээр сумын хэмжээний хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган нийт 5 байгууллагын 10 ажилтан, албан хаагчид байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа, нийгмийн хэв журмын байдалд хяналт тавьж ажилласанд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

БАЙГАЛЬ ОРЧИН

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж 8 ААНБ-ын 60 албан хаагч өөрсдийн байгууллагын хариуцсан талбай болон төвлөрсөн хогийн цэгийн ойр орчмын хог хаягдлыг түүж нийт 4.5 га талбайн 36м3 хог хаягдлыг цэвэрлэсэн.



Нийтийг хамарсан ажилд ажилгүй 10 иргэнийг түр ажлын байраар ханган сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн элс, усалгаа арчилгаа, наадмын талбайн тохижилт хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН

“Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар үйлчилгээ хийх” ажлын гүйцэтгэгчээр “Сүмбэр старлет” ХХК 14,9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээг байгуулаад байна.

Сумын төв талбайг тохижуулах ажлын тендерийг 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул амжилтгүй болсон.

МЭДЭЭ ГАРГАСАН: НЗЭЗАХМ О.БОЛОРМАА

ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА Б.БААСАНБАТ